

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

1.Аудитын гэрчилгээ	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3.Аудитын тайлан.....	9
3.1. Ерөнхий зүйл	9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	9
3.4. Материаллаг байдал.....	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	10
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	10
3.7. Шилэн дансны мэдээлэл	11
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
3.9. Аудитын илрүүлэлт	12
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	12
Аудитын зөвлөмж.....	12
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	12
4. Менежментийн захидал	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
МБСДС	Мэргэжлийн боловсрол сургалтыг дэмжих сан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Г.ӨНӨРБАЯР ТАНАА

2021.03.25 № 01/989
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан нь 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 хөтөлбөрийн хүрээнд 24 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс биелэлт 90.8 хувьтай байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан нийт 24 арга хэмжээнээс бүрэн хэрэгжсэн 18, хэрэгжих шатанд байгаа 5, хэрэгжилт хангалтгүй 1 арга хэмжээ байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	840,450.00	-
33	АВЛАГА	840,450.00	-
33500	Бусад авлага	840,450.00	-
33510	Байгууллагаас авах авлага	840,450.00	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	840,450.00	-
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,799,200,000.00	6,801,600,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,799,200,000.00	6,801,600,000.00
41300	Өглөг	2,799,200,000.00	6,801,600,000.00
41360	Бусад өглөг	2,799,200,000.00	6,801,600,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,799,200,000.00	6,801,600,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-2,798,359,550.00	-6,801,600,000.00
51	Засгийн газрын хувь оролцоо	-2,798,359,550.00	-6,801,600,000.00
51200	Хуримтлагдсан үр дүн	-2,798,359,550.00	-6,801,600,000.00
51210	Өмнөх үеийн үр дүн	-	-2,798,359,550.00
51220	Тайлант үеийн үр дүн	-2,798,359,550.00	-4,003,240,450.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	840,450.00	-

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	25,805,276,600.00	52,295,306,150.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,588,325,000.00	45,700,900,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	18,588,325,000.00	45,700,900,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,588,325,000.00	45,700,900,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,588,325,000.00	45,700,900,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,216,951,600.00	6,594,406,150.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,216,951,600.00	6,594,406,150.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,216,951,600.00	6,594,406,150.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	28,603,636,150.00	56,298,546,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	28,603,636,150.00	56,298,546,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,724,655,084.00	6,593,061,410.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,724,655,084.00	6,593,061,410.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,724,655,084.00	6,593,061,410.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,878,981,066.00	49,705,485,190.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,387,500,000.00	49,703,300,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	21,387,500,000.00	49,703,300,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,491,481,066.00	2,185,190.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,491,481,066.00	2,185,190.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-2,798,359,550.00	-4,003,240,450.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-2,798,359,550.00	-4,003,240,450.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	25,805,276,600.00	52,295,306,150.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18,588,325,000.00	45,700,900,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	18,588,325,000.00	45,700,900,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	18,588,325,000.00	45,700,900,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,588,325,000.00	45,700,900,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,216,951,600.00	6,594,406,150.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,216,951,600.00	6,594,406,150.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	7,216,951,600.00	6,594,406,150.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	25,805,276,600.00	52,295,306,150.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	25,805,276,600.00	52,295,306,150.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,725,495,534.00	6,592,220,960.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,725,495,534.00	6,592,220,960.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,725,495,534.00	6,592,220,960.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,079,781,066.00	45,703,085,190.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,588,300,000.00	45,700,900,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	18,588,300,000.00	45,700,900,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,491,481,066.00	2,185,190.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,491,481,066.00	2,185,190.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-2,798,359,550.00	-2,798,359,550.00
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-2,798,359,550.00	-2,798,359,550.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-2,798,359,550.00	-2,798,359,550.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-4,003,240,450.00	-4,003,240,450.00
2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	-	-	-6,801,600,000.00	-6,801,600,000.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	62,113,004,300.00	52,293,120,960.00	9,819,883,340.00	84.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	62,113,004,300.00	52,293,120,960.00	9,819,883,340.00	84.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,261,820,300.00	6,592,220,960.00	669,599,340.00	90.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,261,820,300.00	6,592,220,960.00	669,599,340.00	90.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,261,820,300.00	6,592,220,960.00	669,599,340.00	90.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	54,851,184,000.00	45,700,900,000.00	9,150,284,000.00	83.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	54,851,184,000.00	45,700,900,000.00	9,150,284,000.00	83.3
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	54,851,184,000.00	45,700,900,000.00	9,150,284,000.00	83.3
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	62,113,004,300.00	52,293,120,960.00	9,819,883,340.00	84.2
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,900,974,300.00	6,592,220,960.00	4,308,753,340.00	60.5
310001	Улсын төсвөөс санхүүжих	10,900,974,300.00	6,592,220,960.00	4,308,753,340.00	60.5
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	51,212,030,000.00	45,700,900,000.00	5,511,130,000.00	89.2
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	51,212,030,000.00	45,700,900,000.00	5,511,130,000.00	89.2
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	41	31	10	75.6
610002	Төсвөөс гадуур байгууллага	41	31	10	75.6
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	16,873	13,105	3,768	77.7
632	МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ	16,873	13,105	3,768	77.7
632002	Хувийн МСҮТ	16,873	13,105	3,768	77.7

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг тус яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийг үндэслэлтэй төлөвлөж, зарцуулах талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 05-наас 2021 оны 03 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын ахлах аудитор Б.Энхжин, аудитор Ж.Нямцэцэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 3/294 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг ерөнхий боловсролын сургуулийг төгсөгчид болон ажилгүй залуучууд, иргэдэд богино хугацаанд нийгэм, хөдөлмөрийн зах зээлд эрэлт хэрэгцээтэй байгаа мэргэжил эзэмшүүлж, ажлын байртай холбох замаар ажилгүйдэл, ядууралтай тэмцэх төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд оршино гэж тодорхойлсон байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг дараах байдлаар хуваарилан зарцуулна гэж заажээ. Үүнд:

- Төрийн өмчийн мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын тогтмол зардал, түүнчлэн сурагчийн дотуур байрны нийт зардал;
- Өмчийн хэлбэр харгалзахгүйгээр мэргэжлийн өөрийн өртгийг үндэслэн тогтоосон нэг сурагчид ногдох хувьсах зардлаар олгосон санхүүжилт, тэтгэлэг;
- Мэргэжил олгох, давтан сургалт зохион байгуулах зардал
- Хувиараа аж ахуй эрхлэгч иргэнийг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх арга барил, ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах зардал байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн

баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 52,298.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 523.0 сая төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 0.8 сая төгрөгөөр буурсан байна

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/сая төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	0.8	-	(0.8)
Нийт хөрөнгө	0.8	0.0	(0.8)
Өр төлбөр	2,799.2	6,801.6	4,002.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	(2,798.4)	(6,801.6)	(4,003.2)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	0.8	0.0	(0.8)

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт орсон нь богино хугацаат өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данс байна.

Авлага дансны үлдэгдэл 0.8 сая төгрөгөөр буурсан нь тайланд оны хувьсах зардлын санхүүжилтийн тооцооноос үүссэн авлага барагдсантай холбоотой байна.

2020 оны 12 дугаар сарын суралцагчдын тэтгэмж, хувьсах зардлыг олгоогүйгээс шалтгаалан өр төлбөрийн дансны үлдэгдэл 6,801.6 сая төгрөг болж 4,002.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн буурахад нөлөөлсөн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан нь 2020 оны төсвийн төсөлд МСҮТ-ын суралцагчдын хувьсах зардлыг санхүүжүүлэхэд улсын төсвөөс 8,395.7 сая төгрөг олгохоор, суралцагчдын тэтгэлгийг санхүүжүүлэхэд Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангаас 79,946.0 сая төгрөг тус тус бүрдүүлэхээр санал өгсөн байна.

Улсын Их Хурлын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн ээлжит бус чуулганаар Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, дагалдах бусад хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг батлахдаа тус сангийн тайлант оны төсвийн санал бодитой биш байснаас тухайн жилд суралцах суралцагчдын квотод хүрээгүй тул МСҮТ-ын суралцагчдын улсын төсвөөс санхүүжүүлэх хувьсах зардлыг 14.0 хувиар бууруулж 7,261.8 сая төгрөгөөр, суралцагчдын тэтгэлгийг санхүүжүүлэхэд Хөдөлмөр, эрхлэлтийг дэмжих сангаас олгох санхүүжилтийг 31.4 хувиар бууруулж 54,851.2 сая төгрөг буюу ирүүлсэн саналаас нийт 26,228.7 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2 хөтөлбөрт зориулан нийт 62,113.0 сая төгрөгийн төсөв батлагдаж, эх үүсвэрийг улсын төсвөөс 10,901.0 сая төгрөгийг, туслах үйл ажиллагааны орлогоос 51,212.0 сая төгрөг бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 6,594.6 сая төгрөг олгож, 4,306.4 сая төгрөг дутуу санхүүжигдсэн нь суралцагчдын тооны бууралтаас шалтгаалсан байна.

Туслах үйл ажиллагааны орлого 54,851.2 сая төгрөгөөр төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 45,700.9 сая төгрөг бүрдсэн нь суралцагчдын тоо 83.3 хувьтай буюу төлөвлөсөн тооноос 3768-аар бага хамрагдсантай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэлээр 52,293.1 сая төгрөг буюу 84.2 хувийг зарцуулсан байна.

Улсын төсвөөс олгосон санхүүжилтээс дутуу зарцуулсан 2.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Мэргэжлийн түр сургалт, МСҮТ-ийн хэв шинжийг агуулаагүй сургалтын төвийн суралцагчдын ирц 75.0 хувиас доош тохиолдолд тэтгэлэг олгоогүй, 2019-2020 оны хичээлийн жилд МСҮТ-д элсэгчдийн тоо төлөвлөснөөс буурсан зэрэг шалтгаанаар 9,819.9 сая төгрөгийн хувьсах болон тэтгэлгийн зардал дутуу зарцуулагдсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан нь шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд оруулбал зохих нийт 151 мэдээллээс 28 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 27,342.6 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгснөөс хэрэгжилт 80.0 хувьтай байна. дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг хуульд заасны дагуу шинэчлэн батлуулах, төсвийг үндэслэлтэй төлөвлөж, гүйцэтгэх талаар өгсөн өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 1 зөвлөмж өглөө.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар залруулагдаагүй 2 алдаа, зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

- Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг Засгийн газрын 2012 оны 94 дүгээр тогтоолоор баталснаас хойш 8 дахь жилдээ мөрдөн ажиллаж байгаа ба өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Боловсролын тухай хуулийн 40.3-т "Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн, аймгийн төвөөс бусад сум, тосгон, багийн сургуульд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүрийг Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно" гэж заасанд нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

- Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан нь Шилэн дансны цахим хуудсанд нийт 151 мэдээлэл оруулахаас 28 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлэлдэг байх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 1 алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар МСҮТ-д суралцаж байгаа суралцагчдын тоо, түүнд хуваарилж буй тэтгэмж болон сургалтын төвийн хувьсах зардлыг бодитой олгож байгаа эсэх талаар аудитын хугацаанд түүврээр хяналт хэрэгжүүлэх боломж дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас суралцагчид цахимаар суралцаж байгаатай холбоотой бодитоор үнэлэх боломж хязгаарлагдмал байсан тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан нь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцах сурагчдын тоог бодитой төлөвлөөгүйгээс төсөв дутуу зарцуулагдсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн дагуу төсвийг төлөвлөхдөө 27.1.2-д "макро эдийн засгийн төлөв байдал, дүн шинжилгээ, тооцоонд үндэслэсэн байх" гэж заасантай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Төсвийн зарчим алдагдах, гүйцэтгэл хэрэгжихгүй байх

1.3. Өгсөн зөвлөмж:

Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, төсвийг бодитой төлөвлөх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Асуудлын бүртгэлийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	“Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/9/СТА-ЗГТС
Шалгагдсан байгууллагын нэр:	“Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан”		Сая төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг Засгийн газрын 2012 оны 94 дүгээр тогтоолоор баталснаас хойш 8 дахь жилдээ мөрдөн ажиллаж байгаа ба өмнөх оны аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	-	Албан шаардлага	ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Нягтлан бодогч	Г.Өнөрбаяр Ц.Эрдэнэтөгс
2	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан нь Шилэн дансны цахим хуудсанд нийт 151 мэдээлэл оруулахаас 28 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	-	Албан шаардлага	ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Нягтлан бодогч	Г.Өнөрбаяр Ц.Эрдэнэтөгс
3	Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан нь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвд суралцах сурагчдын тоог бодитой төлөвлөөгүйгээс төсөв дутуу зарцуулагдсан байна.	-	Зөвлөмж	ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Нягтлан бодогч	Г.Өнөрбаяр Ц.Эрдэнэтөгс
ДҮН		-			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 25

№ 440/А0170076

Улаанбаатар хот

САГ-2021/19/СТА-3ГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар өгсөн “Мэргэжлийн болон техникийн боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын дотуур байрны нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг жил бүр шинэчлэн батлуулах” талаарх зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Боловсролын тухай хуулийн 40.3-т “Сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив, түүний бүрэлдэхүүн, аймгийн төвөөс бусад сум, тосгон, багийн сургуульд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хүүхдийн тооноос хамаарсан өсөн нэмэгдэх итгэлцүүрийг Засгийн газар жил бүр шинэчлэн тогтооно” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан уургээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж, нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг шинэчлэн батлуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, нягтлан бодогч Ц.Эрдэнэтөгс нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

[Signature]

Я.САМБУУНЯМ
Б.ЭНХЖИН
Ж.НЯМЦЭЦЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 03 дугаар сарын 15

№ 421/А0140046

Улаанбаатар хот

САГ-2021/9/СТА-317С

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан нь шилэн дансны цахим хуудсанд нийт 151 мэдээлэл байршуулахаас 28 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлэлдэг байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийн ил тод байдлыг хангаж, тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлэх, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, нягтлан бодогч Ц.Эрдэнэтөгс нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР,
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Я.САМБУУНЯМ
Б.ЭНХЖИН
Ж.НЯМЦЭЦЭГ

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.

[illegible]

[illegible]